ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

**БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**

# ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 29 өдөр Дугаар А/49 Бат-Өлзий сум

Захирамжийн зарим хэсэгт өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, Засгийн газрын "Геодезийн солбилцол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоог батлах тухай" 2022 оны 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2013 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан "Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ийн XXI.1.43-д тусгагдсан "Газрын кадастрын мэдээллийн сан"-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд "Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах геодезийн солбилцол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх" ажил хэрэгжсэнтэй холбогдуулан 1 аж ахуйн нэгжийн газрын хэмжээ өөрчлөгдсөнийг хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгох, улсын бүртгэлд бүртгэх, газрыг зориулалтын дагуу эзэмшиж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (И.Маралмаа)-д үүрэг болгосугай.

3. Дээрхи захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2008 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 51 дүгээр захирамжийн холбогдох хэсгийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА С.АМГАЛАН

622301105

Сумын Засаг даргын ...2023... оны ...03... дугаар
сарын ...29... ны өдрийн ...А/49... дугаар
захирамжийн хавсралт

# ЭЗЭМШСЭН ГАЗРЫН ХЭМЖЭЭ ӨӨРЧЛӨГДСӨН МЭДЭЭЛЭЛ

| Д/д | Өмчлөгчийн | | | Хамтран өмчлөгчийн | | | Өмнөх | | | | | Газрын шинэчилсэн мэдээлэл | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Захирамжийн | | | Газрын | | | | | | |
| | Аж ахуйн нэгжийн нэр | | Регистр | Эцэг эхийн нэр | Өөрийн нэр | Регистр | Огноо | Дугаар | Холбогдох хэсгийн дугаар | Нэгж талбарын дугаар | Хэмжээ /м.кв / | Нэгж талбарын дугаар | Хэмжээ /м.кв / | Байршил | Ашиглалтын зориулалт | Үнэ /төгрөг/ |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 |
| | Хансэнтий ХХК | | 3552497 | | | | 2008.06.03 | 51 | 1 | 6221000510 | 5823 | 6221000510 | 9476 | Рамын дэнж 3-316 тоот | Үйлдвэрийн газар | 13266400 |

--о0о-